

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-21
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	22-73
	1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	26-33
	2.Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2018.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	33-37
	-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	37-38
	3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	39-44
	-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	44-47
	4.“Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 11 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	48-49
	5.Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.10.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	49-52

6.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол нарын 9 гишүүн 2019.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	52-56
7.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	56-60
8.Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	60-62
9.“Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр”-ийн хоёр дахь шатны Хөгжлийн бодлогын санхүүжилтийн хүрээнд Монгол Улс, Олон улсын ассоциаци хоорондын Санхүүжилтийн хэлэлцээр болон Монгол Улс, Олон улсын хөгжлийн сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл/Засгийн газар 2019.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	62-64
10.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл/Засгийн газар 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	65-66
11.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл/Засгийн газар 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	67-69

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 42 гишүүн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 31 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

*Чөлөөтэй: Л.Болд, З.Нарантуяа, Г.Тэмүүлэн, Л.Энхболд, М.Энхболд;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганболд, Ц.Гарамжав;
Тасалсан: О.Баасанхүү, Ц.Даваасүрэн, Б.Наранхүү, Ш.Раднаасэд, А.Ундраа,
Д.Хаянхярваа, Б.Чойжилсүрэн, Ж.Эрдэнэбат;
Хоцорсон: Д.Лүндээжанцан-1 цаг 30 минут, Ц.Мөнх-Оргил-30 минут,
Я.Санжмятав-2 цаг 10 минут, О.Содбилэг-35 минут, Д.Сумъяабазар-1 цаг 40
минут, Б.Энх-Амгалан-40 минут, Л.Энх-Амгалан-2 цаг.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр
нь тохиож байгаа Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн,
Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг нарт Улсын Их Хурлын гишүүдийн
нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад хууль хоорондын зөрчлийг тэгшитгэх, гүйцээн боловсруулах шаардлагатай байгаа тул Байнгын хороог чуулганы хуралдааны дундуур дахин хуралдуулах горимын санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлан, Ж.Батзандан нар үг хэлэв.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 11
Бүгд: 40
72.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны

технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, Хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, референт Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг үргэлжлүүлэн явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, С.Эрдэнэ нар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 8 дугаар саналыг хүчингүй болгох горимын санал хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, С.Эрдэнэ нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 9

Бүгд: 47

80.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж үг хэлэв.

8.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 9

Бүгд: 47

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 30 дугаар зүйлд “30.8 дахь хэсэг нэмэх” гэснийг хасах:

“30.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 40

Бүгд: 48

16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараах “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 12

Бүгд: 48

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 10

Бүгд: 48

79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.9, 22 дугаар зүйлийн 22.4, 28 дугаар зүйлийн 28.9, 28.10, 39 дүгээр зүйлийн 39.8, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дахин” гэснийг, 10 дугаар бүлгийн гарчгийн “нөхөн” гэсний дараах “дахин” гэснийг, 4.4.4, 9 дүгээр зүйлийн 9.11, 76 дугаар зүйлийн 76.7, 79 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 7

Бүгд: 49

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтын “үрэгдүүлсэн” гэсний дараа “санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 8

Бүгд: 49

83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шүүхээс” гэснийг “хуульд заасны дагуу” гэж өөрчлөх, мөн заалтын “тухайн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэснийг “энэ тухай холбогдох байгууллагын шийдвэр гарсан байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 7

Бүгд: 49

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь хэсгийн “шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” гэснийг “хуульд заасны дагуу тогтоогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 7

Бүгд: 49

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт “70” гэснийг “60” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 15

Бүгд: 50

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “40” гэсний дараах “41, 43” гэснийг хасаж, “32,” гэсний дараа “41, 43” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 12

Бүгд: 50

76.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд

доор дурдсан агуулга бүхий 3 дахь хэсэг нэмэх:

“3.Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23, 56 дахь хэсэг, мөн зүйлийн 41, 43.1, 43.2, 43.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 12
Бүгд: 50
76.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Хууль хоорондын зөрчил арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 1 дэх заалтын 17.1 дүгээр зүйлийн 60 дугаар хэсгийн “45” гэснийг “30” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 14
Бүгд: 50
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

12 цаг 10 минутаас Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд хууль болон Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /12:18/

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгд, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёр, Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг.

Гуравт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Дөрөвт нь, “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны Стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тавд, Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Зургаад, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Долоод, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Наймд, Санхүүгийн хамтын ажиллаганы ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Ес, “Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр”-ийн хоёр дахь шатны Хөгжлийн бодлогын санхүүжилтийн хүрээнд Монгол Улс, Олон улсын ассоциаци хоорондын Санхүүжилтийн хэлэлцээр болон Монгол Улс, Олон улсын хөгжлийн сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл

Аравт, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Арван нэг, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Арван хоёр, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн

мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийн цаг. Төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн талаар сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Сонгуулийн хууль нэлээн нухацтай хэлэлцэх асуудал, 2020 оны сонгууль болох гэж байна. Тоглоомын дүрмээ улс төрчид зөв тогтоож, зөв тохирч шударга өрсөлдөх ийм бололцоо боломжийг хангах ёстой. Өчигдөр хэлэлцүүлгийн явцад зарим нэг саналууд дээр анхаарах асуудлууд гарсан. Тухайлбал, эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслээс гарсанд тооцно гэж. Ингэхгүй бол эвслээс нэг нам гарахад үндсэндээ тэр эвссэн намууд бүгдээрээ сонгуульд оролцох бололцоо боломжгүй болж байгаа юм. Тийм болохоор энэ асуудлыг Байнгын хороон дээр дахиж ярих шаардлага байгаа. Томьёолол өчигдөр өөр хураагдсан учраас.

Дараагийн асуудал, нэрсийн жагсаалттай холбоотой асуудлыг бид анхаарах ёстой. Мөн Зөрчлийн хууль болон Сонгуулийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль гээд иймэрхүү асуудлыг ярих шаардлагатай байгаа юм. Тийм болохоор Их Хурлын даргаас санал хураалтын дараа Төрийн байгуулалтын байнгын хороог дахиж хуралдах бололцоо боломжийг бүрдүүлж өгөөч ээ гэж нэгдүгээрт нь хүсье.

Үнэхээрийн богино хугацаанд Сонгуулийн хуулийг бид баталж байгаа. Сонгуулийн хуулийн нийтдээ 85 зүйлээс 60 гаруй зүйл буюу 70 орчим хувьд өөрчлөлт орж байгаа. Нэг дэх өдөр бид бүлгийн хурлаар өргөн барьсан 50:26 тогтолцоог өөрчлөөд олон мандаттай томсгосон тойрог болгож өөрчилсөн. Үүнтэй холбоотой маш их өөрчлөлт орж байгаа.

Хоёр дахь өдөр ажлын хэсэг хуралдсан, Байнгын хороо хуралдсан. Гурав дахь өдөр ажлын хэсэг, чуулган хуралдсан, дахиад ажлын хэсэг хуралдсан. Өчигдөр Байнгын хороо, чуулган хуралдсан. Үнэхээр Их Хурлын Тамгын газар, ажлын хэсэг нойр хоолгүй, өдөр, шөнөгүй ажиллаж байгаа. Энэ явцад бага зэргийн алдаанууд гарсан бол Их Хурлын гишүүдээс хүлцэл өчье. Энэ

алдаануудыг өнгөрсөн шөнө сууж заслаа. Тийм учраас Сонгуулийн хууль ямар нэгэн алдаагүй, зөв, олон нийт, улс төрийн намуудтай зөвшилцөөд, ингээд хэл амгүй баталчихмаар байгаа юм. Хэн нэгэнд давуу тал олгох ийм бололцоо боломжийг бий болгохгүй байх, хүн болгон тэгш шударга өрсөлдөх бололцоо боломжийг энэ Сонгуулийн хуулиар улс төрчдөд олгох ёстой. Энэ үүднээс МАН хандаж байгаа. Ямар нэгэн байдлаар МАН өөртөө давуу тал олгосон ийм зүйл байхгүй шүү. Энэ дээр та бүгдийг хэт хийрхэлгүй, бас хэт их улс төржилгүй Сонгуулийн хуулиа аль болох эрүүл нүдээр хараад, аль болох зөвшилцөж ойлголцоод батлах байр суурийг баримталж ажиллаасай гэдгийг хүсэж байна. Асуудал байх юм бол дор дор нь засаад явах бололцоо боломж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Санал хураалтын дундуур юм уу?

С.Бямбацогт: Санал хураалтын төгсгөлд түр завсарлаад. Хүсэлт тавьж байгаа юм.

Г.Занданшатар: Горимын саналыг санал хураалтаар шийдэх юм байна. Бямбацогт гишүүний гаргасан горимыг саналаар санал хурааж байж, Байнгын хороо хуралдаж, гүйцээн боловсруулах, хууль хоорондын зөрчлийг тэгшитгэх шаардлага гарна. Гүйцээн боловсруулах гэдэг дээр нэгдүгээрт нь, Сонгуулийн хуулийг мөрдөж эхлэх хугацаагаа товлгоогүй байгаа юм байна. Тийм учраас Байнгын хороо дахиж хуралдах шаардлагатай.

12 санал үлдсэн байгаа юм. Шууд гүйцээн боловсруулах чиглэл өгөөд хуралдуулж болох юм биш үү? Санал хураалт явуулах шаардлагатай юм уу? Үгүй юу?

12 санал хураалтаас үлдсэн байгаа. Санал хураалтуудаа дуусгаад, 1 асуудал дээр дахиж хуралдаж, гүйцээн боловсруулах шаардлагатай. Бас Сонгуулийн хууль хэрэгжиж эхлэх хугацаагаа хэлэлцээгүй орж ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороо түүнийгээ гүйцээн боловсруулах шаардлагатай байгаа учраас 10 минут завсарлаад, эргэж хуралдахаар дараалалд өөрчлөлт оруулах саналыг горимын санал гэж үзнэ.

Бямбацогт гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

72.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд ийм байдлаар өөрчлөлт оруулна.

Эхний асуудлаар санал хураалт явуулаад шийдлээ.

Самандын Жавхлан гишүүн үг хэлнэ.

С.Жавхлан: Зарчмын зөрүүтэй санал дээр урлагийг нээх санал хүргүүлсэн байсан, өчигдөр саналыг хүлээж аваагүй Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдэд эмгэнэл илэрхийлье. Ээжээс бүүвэйн дуу сонсож өсөөгүй юм шиг, үе үеийн бүх хувьсгалууд дуугаар гарсан байдаг. Хонхны дуугүйгээр, улаан тугийг мандуулаад, улсын сүрийг бадруулаад гэдэг дуугүйгээр. Монгол түмэн дуугүйгээр найр, наадмаа хийдэггүй дууч түмэн олон. Тэгээд энэ дээр эсрэг саналтай гишүүдийг би бүгдийг зарлана, өнөөдөр бүх бичлэгийг гаргаад тавьсан байгаа. Энэ 2020 оны сонгуульд дандаа нэг нэгийгээ хараадаг хараал өргөдөг сонгууль болох гэж байна. Ядаж дуу хуураа нээгээд өгөөч ээ гээд зарчмын зөрүүтэй санал явуулаад оруулахаар зэрэг унагасан байна. Үүнийг буцааж оруулж ирж та бүхэн хэлэлцүүлж, энэ заалтуудыг ямарваа нэгэн боломжийн хэмжээнд нь тавьж, хэлэлцүүлж өгөөч гэдэг саналыг би дахиад тавьж байна. Би энэ эсрэг санал өгсөн бүх гишүүддээ цаашдаа айхтар хагаралдаж битгий муудалцаарай гэж хэлмээр байна. Тэгээд энд бодитой хариу өгөөч.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудал дотроо Сонгуулийн хууль дотроо хэлэлцэх асуудал байна. Үүнийг Байнгын хороон дээрээ орж саналаа тавьж ярилцах байх. Дэгээрээ асуулт, хариулт хэлэлцэх асуудалд байхгүй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бямбацогт тодруулаад хариулна биз.

Ингээд Жалбасүрэнгийн Батзандан гишүүн үг хэлнэ.

Ж.Батзандан: Сонгуулийн хууль гэдэг бол сонгогчдын хууль юм.

Сонгуулийн хууль гэдэг зөвхөн эрх баригч намын хууль бишээ. Парламентад суудалтай намуудын ч хууль биш. Парламентын гадна байгаа 30 гаруй намууд сонгуульд оролцох учраас энэ намуудын эрх ашгийг хангасан хууль гарах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Сонгуулийн хууль зөвхөн улс төрчдийн хууль биш, сонгогчдын хууль байгаа юм. Энэ агуулгаар нь парламентын гадна байгаа улс төрийн 20 гаруй нам нэгдэж, 5 тодорхой саналыг, 20 орчим найруулгын шинжтэй саналуудыг хүргүүлсэн боловч эрх баригч намын дарга, удирдлагууд хүлээж авахгүй байгаа юм.

Нямдорж гуай, ялангуяа би танд хандаж нэг зүйл хэлэхийг хүсэж байна. Өчигдөр Нямдорж гуай эвслийн асуудал дээр онцгой анхаарал хандуулаарай гэж хэлсэн. Монголын 30 жилийн түүх бол эвсэл байгуулагддаг, эвслээс нь нэг нам гараад, эвслийг задалдаг. Нэг намын дарга уурлахаараа төрийн тогтворгүй байдлыг эвслийг задлах маягаар үүсгэдэг ийм л 30 жил байсан. Энэ 30 жилийг төгсгөл болгооч ээ гэж хүний эрхийн байгууллагууд Монгол Улсад санал хүргүүлж байна. Одоогийн хуулиар эвсэл байгуулаад Сонгуулийн ерөнхий хороон дээр очиход л нэг намын дарга нь уурлаад, эвслээс гарлаа гэхэд гудамжинд байгаа 30 нам чинь сонгуульд оролцох чадамжгүй болж байна шүү. Ийм учраас эмзэг эвсэл дээр тоглосон эмзэг 30 жилийг төгсгөл болгож, бат бэх эвсэл хийдэг, бат бэх төртэй 30 жилийг бий болгохын төлөө парламентын суудалгүй намуудтай ШИНЭ нам зөвшилцөж, эвсэлд нэгдсэн намуудын зөвхөн олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцдог болъё. Зүгээр нэг намын дарга авлига аваад Монголын бүх улс төрийн эвслүүдийг тараадаг явдлыг таслан зогсооё гэдэг ийм саналыг оруулсан юм. Зарим улс төрчид үүнийг ойлгож байгаа хэдий ч ойлгоогүй юм шиг дүр эсгэж байна.

Хоёр нам эвсэл байгуулсан тохиолдолд олонх нь гэдэг бол хоёулаа 100 хувь ойлголцолд хүрсний дараа л эвсэл тарна гэсэн үг. 3 нам эвсэл байгуулсан тохиолдолд 3-ын 2 нь эвслээ тараа гэж шийдвэр гаргасан тохиолдолд эвсэл тарна гэсэн үг. 5 нам эвсэл байгуулсан тохиолдолд 3 нь эвслийг тараа гэдэг шийдвэр гаргасны дараа эвсэл тарна гэсэн үг. Үүнийг ойлгохгүй, мэдэн будилж байгаа зарим улс төрчдийг хараад би гайхаж байна. Эвслийг тарааж, бутаргаж, Монголыг тарааж бутаргасан 30 жилийг төгсгөл болгоё, хамтдаа. Монголын улс төрийг тогтвортой болгохын төлөө эрх баригч нам бас дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэж байна. Иргэд олон түмэн, олон улсын байгууллага, парламентын суудалгүй улс төрийн намуудын 5 шаардлагын зөвхөн 1-ийг нь хүлээж аваач ээ гэж би та бүхнээс хүсэж байна.

Энэ Сонгуулийн хууль бол маш эмзэг Сонгуулийн хууль шүү. 2008 онд энэ системээр сонгууль хийж үзсэн, дараад нь 7 сарын 1 болсон. Өнөөдөр Ардчилсан

нам парламентын суудалгүй 20 гаруй намуудын 2-хон шаардлага байна. Энэ хоёрыг нь хүлээгээд аваач ээ, дэмжиж өгөөч ээ. Сонгуулийн хууль гэдэг улс төрийн намуудын зөвшилцөл дээр гарах ёстой хууль гэдгийг та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Энэ шаардлагуудыг хүлээж авахгүй бол гадаа гудамжинд байгаа 30 нам чинь сонгуульд оролцохгүй гэж мэдэгдэж байна. Цагаан сонгууль хийнэ гэж уриална гэж ярьж байна. Эрх баригч МАН-ыг буурьтай тулхтай нам юм бол бусад намуудтай хүндэтгэлтэй хандаач ээ гэж хүсэж байгаагаа илэрхийлье.

Баярлалаа та бүхэнд.

Г.Занданшатар: Батзандан гишүүний хэлсэн санал сая Бямбацогт даргын хэлсэн саналаар гүйцээн боловсруулах чиглэлд багтаад, Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж гүйцээн боловсруулахаар горимын саналаар шийдвэрлэгдсэн учраас энэ асуудлаар дахин санал хураах бололцоогүй.

Одоо хэлэлцэх асуудалд оръё.

Сонгуулийн хуулийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Нэг.Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Болдсайхан, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Хууль эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Баасандорж, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Нармандах, мэргэжилтэн Дэлгэрмөрөн, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Нямдаваа, Цагдаагийн зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил зохицуулалтын хэлтсийн дарга Лувсан-Очир, Харилцаа холбооны зохицуулах хорооны интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Батболд, Хуульч, өмгөөлөгч

Эрхэмбаатар, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах албаны дарга, ахлах комиссар Даваатогтох, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч Чинбат.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн санал хураана.

Бямбацогт гишүүн. Дараа нь Эрдэнэ гишүүн.

С.Бямбацогт: Баярлалаа. Өчигдөр 8 дахь саналаар санал хурааж байгаад энэ санал дэмжигдээгүй. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдэд сонгогчдын эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно гэсэн санал. Энэ дээр нэлээн ярилцсан юмаа, Байнгын хороон дээр ярилцсан, Ажлын хэсэг дээр ярилцсан.

Улсын бүртгэлийн тухай хуулиар олгох нь тодорхой хуулиар зохицуулна гэсэн заалттай. Үүнийг олгоход сонгогчид маань бухимддаг, миний хаягийг, миний регистрийн дугаарыг яагаад олон нийтэд өгч байгаа юм бэ? Улс төрийн намуудад гэдэг байдлаар гомдол гардаг. Үүнийг ажлын хэсэг дээр ярилцаад уг нь өгөхгүй гэж шийдсэн байсан. Гэхдээ Ардчилсан намаас ялангуяа санал тавьж байгаа, асуудал ярьж байгаа. Сонгуулийг та нар өөрсдөдөө давуу байдал бий болгоод сонгуулийг будилаантуулах гэж байна, өөрсдөө давуу байдлаар сонгуульд оролцох гэж байна гэж ярьж байгаа. Тийм учраас бид нар үүнийг эргэж харъя, ярилцъя гээд нийтэд нь өгдөг байя гэдгийг Байнгын хороон дээр ярилцаад хураасан юм. Гэтэл энэ санал чуулган дээр дэмжлэг аваагүй. Сонгуульдаа шударгаар оролцъё. Хамгийн гол нь нэрсийн жагсаалтыг зөв зорилгоор зөв ашиглаасай. Олон нийтэд төөрөгдөл үүсгэхгүй, будилаан үүсгэхгүй байх талд бид анхаарах ёстой. Энэ үүднээсээ горимын саналаар энэ саналыг хүчингүй болгох дахин санал хураалт явуулж өгөх саналыг гаргаж байна.

Тэгээд сонгуульд орох бүх улс төрийн намуудад энэ сонгогчдын нэрсийн жагсаалтад өгдөг байя гэж байгаа юм. Энэ дээр Улсын бүртгэлийн ерөнхий газраас холбогдох асуудал яригддаг. Хүнийг хувилаад ихэр хүмүүсийг санал өгүүлчихлээ. 100 гаруй билүү ижил овог, нэртэй хүмүүс байдаг. Гэтэл энэ ижил овог, нэртэй хүмүүсийг сонгуульд оролцуулж, сонгуулийг будилаантуулж байна гэдэг байнга хардлага, эргэлзээ тээнэгэлзлэл төрүүлдэг. Үүнтэй холбоотой

асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар өчигдөр Байнгын хороон дээр ярьсан.

Зөвхөн Болдын Жавхлан нэртэй 20-30-аад хүн Монгол Улсын хэмжээнд байна гэж байгаа. Яг үүнтэй адилхан овог, нэр нь адилхан, регистрийн дугаарын сүүлийн 2 оронгоос бусад нь бүгд адилхан, хаяг нь адилхан ийм хүмүүс байдаг. Энэ бүгд ямар хүмүүс байгаа талаар тодорхой мэдээлэл өгч, эргэлзээг тайлахгүй бол дараад нь энэ хүмүүсээс чинь болоод -өө Бямбацогтыг хувилаад 10 Бямбацогт болгоод санал өгчихлөө, Эрдэнэбатыг хувилаад 100 Эрдэнэбат болгоод санал өгүүлчихлээ гэдэг тийм асуудал яригдана. Тийм болохоор энэ дээр тийм боломж байдаг уу, байдаггүй юу гэдэг талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрынхан, Сонгуулийн ерөнхий хорооноос тодорхой хариултыг өгч, нэгдсэн нэг ойлголттой болмоор байна. Тэгэхгүй буруу мэдээлэл дээр, мушгиж гуйвуулсан мэдээлэл дээр сүүлд нь эргэлзээ тээнэгэлзлэл үүсдэг, эргэлзээ тээнэгэлзээ нь асуудал болох вий.

Тийм болохоор нэг мөр ярьж байгаа дээрээ үүнийг нэгмөсөн яриасай. Тийм учраас би 8 дахь саналыг хүчингүй болгох горимын саналыг хураалгаж өгөөч ээ гэж хуралдаан даргалагчаас хүсье.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо Содномзундуйн Эрдэнэ гишүүн.

С.Эрдэнэ: Баярлалаа. Би бас яг энэ Бямбацогт гишүүний оруулж байгаа 8 дахь саналыг дэмжиж байна. Тэгээд энэ саналыг хүчингүй болгоод, өчигдрийн гаргасан шийдвэрийг. Тэгээд дахин энэ саналыг дэмжихээр санал хураалтыг явуулж өгөөч ээ гэж хүсэж байна. Угаасаа Байнгын хороогоор оруулаад, хэлэлцээд, Байнгын хороо дэмжээд оруулаад ирсэн санал. Өчигдөр санал хураалтын үйл явц дундуур хуралдаан удирдаж байсан нөхөр маань өөрөө бусдад энэ саналыг дэмжихгүй байхыг уриалж, санал хураалт явуулсан. Үүний улмаас энэ саналын үр дүн би буруу гарсан гэж харж байгаа юм.

Хоёр дахь үндэслэлийг юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр, өнөөдөр өмнөх сонгуулиудад энэ сонгогчдын нэрсийн жагсаалт, регистрийн дугаар бүх юм өгөгддөг байсан. Хоёр ч сонгуулиар энэ хэвийн ингээд яваад ирсэн ийм асуудал. Энэ дээр өнөөдөр гэнэтхэн үүнийг болиулах гээд байгааг гайхаж байна.

Гуравдугаарт, энэ сонгуулийг ил тод, нээлттэй явуулах нь өөрөө дараа нь хэл амгүй, Монгол төрийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад ийм чухал гэж

харж байгаа. Улс төрийн намуудын хувьд бид нар хэн хэндээ хүндэтгэлтэй хандаад, харилцан ойлголцоол энэ саналыг дэмжээд яваач ээ гэж би эрх баригч Ардын намаас хүсэж байна. Энэ сонгогчдын нэрсийн жагсаалт ил тод, нээлтэй байснаар энд буруудах зүйл ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ дээр бид нар сонгуульд оролцохдоо аль аль талдаа хардах сэрдэх зүйлгүйгээр нээлттэй, хяналттай, иргэд сонгогчдын өргөн хяналт дор нээлттэй энэ сонгуулийг явуулах боломжийг хангах нь одоо энэ Сонгуулийн хуулийн бас нэг зорилго гэж харж байгаа.

Тийм учраас Бямбацогт гишүүний гаргасан саналын дагуу энэ санал дээр санал хурааж, өчигдрийн шийдвэрийг хүчингүй болгоод, эргээд энэ саналыг дэмжих асуудлаар санал хураалт явуулж өгөхийг хуралдаан даргалагчаас хүсэж байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны оруулж ирсэн анхны саналаар нь. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Одоо ажлын хэсэг дээр тохироод, сонгуулийг хардлага, сэрдлэг, будилаан зөрчилгүй явуулах, хяналт тавих зорилгоор нь 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр 1 удаа нэрсийн жагсаалтын тодорхой хэсгийг улс төрийн намуудад 20 хоногийн өмнө хүргүүлэх тухай заалтыг ажлын дэд хэсэг, ажлын хэсэг, намуудын төлөөлөлтэй ярьж ойлголцсон юм байна.

Тэгээд энэ дээр үл ойлголцол гараад энэ санал унасан учраас энэ саналыг хүчингүй болсонд тооцох тухай санал хураалт явуулж өгөөч гэсэн горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Эрдэнэ нар гаргалаа. Гишүүд санал хураалтад анхааралтай оролцож энэ саналыг шийдэх нь зүйтэй байна.

Санал хураалт явуулъя.

80.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тийм учраас энэ санал хураалтыг дахин явуулна. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт дэмжигдсэн. Тийм учраас энэ 8 дугаар асуудлаар санал хураалт явуулна.

Цэндийн Нямдорж гишүүн үг хэлнэ.

Ц.Нямдорж: Гишүүд ээ, энэ явдалтай асуудал шүү. Зарчмын хувьд тэр нэрийн жагсаалтыг өгөөд болох байх. Болгоомжлох юм байна. Тэр авсан газар нь регистрийн дугаар, хаяг хоёрыг задруулахгүй байх давхар үүрэг хүлээлгэх асуудлаар дараагийн Байнгын хорооны хурал дээрээ давхар түгжээ хий. Тэр тохиолдолд наадах чинь болж байна. Тэгээд хүлээж авчхаад, хүний регистрийн дугаар, гэрийн хаяг хоёрыг сонгуулийн штабынхан тараагаад байж болохгүй шүү дээ. Цаад талд нь хүний нууцын асуудал, амьдралын асуудал, хувь заяаны байгаа. Тэгээд энэ санал дэмжигдэх юм шиг байна, би уур амьсгалыг нь тэгж харлаа.Хэрвээ дэмжигдэхээр бол тэр регистрийн дугаар, хаяг хоёрыг задруулахгүй байх арга хэмжээг тэр авсан хүмүүст нь хүлээлгэсэн давхар заалтыг дагуулж оруулж ирээрэй. Тэгэхгүй бол одоо яг мөрдөж байгаа хуультай наад регистрийн дугаар, хаяг хоёр чинь хязгаарлагдмал нууцын зэрэглэлд байгаа шүү, Бүртгэлийн хуулиараа. Гишүүд минь хууль битгий зөрч нэгдүгээрт. Хоёрдугаарт саяны түгжээг хийж өгөө. Тэгээд авсан газар нь маргаан гарах юм бол түүнийг аваачаад задруулахгүйгээр асуудлаа ярьдаг байх хэрэгтэй. Ер нь энэ хүний регистрийн дугаар, хувийн нууцад ингэж задрах бололцоо гаргаад байгаа нь зохистой биш. Тэгэхдээ би энэ сонгуулийн маргаан элдэв юмыг ойлгож байна. Тэр давхар түгжээг нь хийж өгөөрэй гэж хэлэх гэсэн юм, Бямбацогт гишүүнд.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багш ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш ажилтнууддаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе /Алга ташив/.

Баасандорж дарга үүнийг анхаараад, тэр чинь хувь хүний нууц задруулахгүй гэсэн заалт байгаа шүү дээ, тийм ээ. Дор нь хийсэн байх.

Санал хураалт.

73.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 30 дугаар зүйлд “30.8 дахь гэсэн хэсэг нэмэх” гэснийг хасах:

“30.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.”

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Үүнийг хасах гэсэн санал Байнгын хороон дээр дэмжигдсэн. Хоёрдугаар хэлэлцүүлгээр үүнийг дэмжээд орсон байсныг гуравны хоёроор Байнгын хороон дээр хасахаар орсныг одоо дэмжих саналын томъёоллоор санал хураалт явагдана.

Санал хураалт.

Энэ хасах санал дэмжигдсэнгүй.

10.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараах “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

75.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь заалтыг хасах.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт.

79.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10 болон 11 дэх санал дэмжигдсэн тохиолдолд дараах 12-оос 15 дахь саналуудыг хураана.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.9, 22 дугаар зүйлийн 22.4, 28 дугаар зүйлийн 28.9, 28.10, 39 дүгээр зүйлийн 39.8, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дахин” гэснийг, 10 дугаар бүлгийн гарчгийн “нөхөн” гэсний дараах “, дахин” гэснийг, 4.4.4, 9 дүгээр зүйлийн 9.11, 76 дугаар зүйлийн 76.7, 79 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах.

13.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтын “үрэгдүүлсэн” гэсний дараа “, санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт явуулъя.

Энэ чинь нэг л бичигдсэн юм байна шүү дээ. Дугаар нь тусдаа, тэгэхдээ

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн гээд нэг л санал хураалт байна. Тэгж бичиж өгсөн байна.

Дахин санал хураалт явуулъя. Санал 79.6 хувиар дэмжигдсэн. Тэгэхдээ салгаад дахин хураалгая гэж Байнгын хороо тэгж байна. Уг нь хамт бичээд өгсөн байна шүү. Энэ юмнуудаа нягтал л даа.

10 болон 11 дэх санал дэмжигдсэн тохиолдолд дараах 12-оос 15 дахь саналуудыг хураана.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.9, 22 дугаар зүйлийн 22.4, 28 дугаар зүйлийн 28.9, 28.10, 39 дүгээр зүйлийн 39.8, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дахин” гэснийг, 10 дугаар бүлгийн гарчгийн “нөхөн” гэсний дараах “, дахин” гэснийг, 4.4.4, 9 дүгээр зүйлийн 9.11, 76 дугаар зүйлийн 76.7, 79 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт явуулъя.

85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн.

13.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтын “үрэгдүүлсэн” гэсний дараа “, санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт.

83.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Санал хураалтад 49 гишүүн оролцож, 41 гишүүн дэмжиж, 83.7 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шүүхээс” гэснийг “хуульд заасны дагуу” гэж өөрчлөх, мөн заалтын “тухайн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэснийг “энэ тухай холбогдох байгууллагын шийдвэр гарсан байх” гэж өөрчлөх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 49 гишүүн оролцож, 42 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь хэсгийн “шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” гэснийг “хуульд заасны дагуу тогтоогдсон” гэж өөрчлөх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт явуулъя.

85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт “70” гэснийг “60” гэж өөрчлөх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт явуулъя.

70.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Агваансамдангийн Сүхбатын урилгаар Төв аймгийн Үндэсний бөхийн холбооны гишүүн улс, аймаг, сумын цолтой бөхчүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Бөхчүүддээ эрүүл энх, сайн сайхан, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Одоо Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “40” гэсний дараах “41, 43” гэснийг хасаж, “32,” гэсний дараа “41, 43” гэж нэмэх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт.

76.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 3 дахь хэсэг нэмэх:

“3.Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23, 56 дахь хэсэг, мөн зүйлийн 41, 43.1, 43.2, 43.3 дахь заалт хамаарахгүй.”

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт явуулъя. Санал хураалт.

76.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Хууль хоорондын зөрчил арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 1 дэх заалтын 17.1 дүгээр зүйлийн 60 дугаар хэсгийн “45” гэснийг “30” гэж өөрчлөх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт.

72.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ асуудлыг өглөө гаргасан горимын саналын дагуу түр завсарлаж, Төрийн байгуулалтын байнгын хороо “Б” зааланд хуралдана.